



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2016.03.31 № 575

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН, ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Ч.УЛААН ТАНАА**

Үндэсний аудитын газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайланг хүргүүлэв.

Хүлээн авч, холбогдох арга хэмжээ авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР **А.ЗАНГАД**



\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0331GAG6.Docx

073366



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн
хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан*



**ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАСАН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ
САЛБАРУУДЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

Улаанбаатар хот
2016 он



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор:
М.Наранжаргал

Чиглэлийн аудитын албаны менежер: Д.Баттулга

Ахлах аудитор Ж.Эрдэнэ
Б.Болормаа

Аудитор, шинжээчид
М.Доржмаа
Ш.Наранбаатар
Г.Мөнхчимэг
С.Одонцэцэг

*Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 263755, 262451, 261456 дугаарын утсаар харилцана уу.
Аудитын тайланг ҮАГ-ын "www.audit.mn" сайтаас үзнэ үү.*

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

Товчилсон үгийн жагсаалт 4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл 5

Аудитын хураангуй

- Оршил 6
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал

Бүлэг 1. Зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тогтоогоогүй байна 7

- Үндсэн чиглэлд үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, хувиар үнэлэх арга хэмжээ төлөвлөгдөж байна. 8
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ бодитой бус төлөвлөгдсөн байна 9

Бүлэг 2. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 70 орчим хувийн биелэлттэй байна 10

- Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зарим зорилт хангагдаагүй байна
- Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хэрэгжилт, үр дүн бага байгаагаас үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй байна 11
- Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилт 67.7 хувьтай байна 12
- Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний биелэлт 82.9 хувьтай байна
- Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын зарим зорилт арга хэмжээ төлөвлөлтөөс шалтгаалан дутуу хэрэгжсэн байна 13
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд төлөвлөгдсөн хөрөнгийн 80 орчим хувьд санхүүжилт олгогдоогүй байна

Бүлэг 3. ТЕЗ-д үндсэн чиглэлийн биелэлт, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна	14
▪ Зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгоогүйгээс үнэлэхэд хүндрэлттэй байна	15
Аудитын дүгнэлт	17
Аудитын зөвлөмж	18
Холбогдох байгууллагын санал:	
ЗГХЭГ-аас ирүүлсэн санал	19
Саналд өгсөн тайлбар:	21
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ	22
Хавсралт №1. “Үндсэн чиглэлийн хэрэгжилт дутуу зорилт, арга хэмжээний жагсаалт”	23
Хавсралт №2. “Үндсэн чиглэлийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний жагсаалт”	25

Товчилсон үгийн жагсаалт

АУЯ	Аж үйлдвэрийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗГУАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТЯ	Зам, тээврийн яам
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НТ	Нэгдсэн төсөв
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
УАГ	Үндэсний аудитын газар
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЯ	Хөдөлмөрийн яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХШУДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Үндсэн чиглэлийн арга хэмжээ оновчтой төлөвлөгдсөн эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц үр нөлөөтэй ажлыг зохион байгуулсан эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг тооцсон эсэх.

Хамарсан хүрээ

Улсын Их Хурлын 2014 оны 53 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн 15 яам, 4 агентлаг, Монголбанк зэрэг төсвийн ерөнхийлөн захирагч нарын хариуцсан үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт биелэлтийг хангах талаар зохион байгуулсан арга хэмжээ, түүний үр дүнг үнэлсэн болно.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан биелэлтийн тайланд судалгаа хийж үнэлэх,
- Хөрөнгийн эх үүсвэрийн уялдааг судлах, гүйцэтгэлийг харьцуулах,
- Холбогдох төрийн байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, тоон мэдээлэл гаргуулан судлах,
- Үндсэн чиглэлийн хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлсэн яамдын дотоод аудитын нэгжийн үнэлгээ, тайланг судлах, ҮАГ-аас 2015 онд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлыг судлах,
- ТЕЗ бүрээр үндсэн чиглэлийн хэрэгжилтийг байдлыг үнэлэх,
- Статистикийн байгууллагаас гаргасан улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, төрөөс баримтлах урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт материалд тулгуурлан судалгаа хийх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн нотлох зүйлстэй тулган шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын хураангуй

Оршил

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хариуцсан яам, агентлагууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлсэн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулсан бөгөөд түүний үндэслэл, хүчин зүйлсийн нөлөөлөл, нөхцөл байдлын талаарх дүнг холбогдох дарааллаар тайлангийн I, II, III бүлэгт харуулав.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 91 арга хэмжээнд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоос 10 арга хэмжээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 61 арга хэмжээ, бусад бодлогын баримт бичгээс 20 арга хэмжээ тусгагджээ.

Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Сангийн яам 81.7 хувиар, ЗГХЭГ 76.1 хувиар тус тус үнэлсэн байна.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, арга зүйн дагуу хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний дүнгээр нийт 91 арга хэмжээнээс хэрэгжсэн 45, хэрэгжилт дутуу 35, хэрэгжээгүй 11 буюу биелэлт 70.0 хувьтай байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөөгүй, хэрэгжилт биелэлтэд ТЕЗ-дын удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг дутагдсанаас зорилт, арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар ТЕЗ-даас зохион байгуулж, үр дүнд хүрсэн ажил хангалтгүй байгаа нь асуудлыг шийдвэрлэх талаар санаачлага дутагдаж байгааг харуулж байна.

Бүлэг 1. Зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг оновчтой тогтоогоогүй байна

1.1 УИХ-ын 2014 оны 53 дугаар тогтоолоор эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын бусад бодлоготой уялдуулан баталсан байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 5 бодлогын хүрээний нийт 24 зорилт, 91 арга хэмжээ тусгагджээ.

Хүснэгт 1.1

Бодлогын хамрах хүрээ	Бодлогын хүрээний зорилтын тоо	Зорилтын хүрээний арга хэмжээний тоо
Макро эдийн засгийн бодлого	4	10
Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарын бодлого	6	25
Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	4	13
Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	5	21
Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	5	22
НИЙТ ДҮН	24	91

1.2 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 91 арга хэмжээнд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоос 11 хувь буюу 10 арга хэмжээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 67 хувь буюу 61 арга хэмжээ, бусад бодлогын баримт бичгээс 22 хувь буюу 20 арга хэмжээ тусгагджээ.

1.3 Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээний тоо 2015 онд өмнөх оноос 13-аар буурч, эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээний асуудал нийт арга хэмжээнд 27.4 хувийг эзэлж байна.

1.4 Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт ороогүй, төлөвлөлт, судалгаа, тооцооллын үндэслэлийг сайжруулах талаар өмнөх жилүүдтэй харьцуулахад ахиц дэвшил ажиглагдахгүй, зарим арга хэмжээний төсвийн эх үүсвэрийг буруу тооцсон, арга хэмжээ давхардан орсон зэрэг нь холбогдох байгууллагуудын хяналт сул байсантай холбоотой байна.

1.5 Үндсэн чиглэлд туссан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдэд хэрхэн төлөвлөж байсныг харьцуулан авч үзвэл,

Хүснэгт 1.2:

Зорилт, арга хэмжээний төлөвлөлт	Хүрэх түвшин /оноор/				
	2011	2012	2013	2014	2015
ДНБ-ий бодит өсөлт /%-уар/	8.2	16.6	19.0	14.7	10.2
Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ /ам.долл/	2076.5	3900.0	4930.0	5300.0	5000.0
Инфляцийн түвшин /%-уар/	9.7	9.0	8.0	6.0	7.0
ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь	35.4	29.8	39.2	32.1	25.8
ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын эзлэх хувь	40.4	36.5	41.2	33.9	30.8
ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	5.0	6.7	2.0	2.0	5.0

1.6 Макро эдийн засгийн зарим үзүүлэлтийн хувьд 2015 онд ДНБ-ий бодит өсөлтийг 10.2 хувьд, инфляцийн зорилтот түвшинг 7.0 хувьд байлгах, төсвийн алдагдлыг бууруулан тогтвортой байдлыг хадгалах зэргээр эдийн засгийн өсөлтийг хангах бодлого, зарчмыг мөрдлөг болгохоор төлөвлөсөн байна.

Үндсэн чиглэлд үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, хувиар үнэлэх арга хэмжээ төлөвлөгдөж байна

1.7 2015 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж үзэхэд тодорхой шалгуур үзүүлэлтээр бус ажлын явц, хэрэгжилтийн хувиар үнэлэх арга хэмжээний тоо буураагүй, хөрөнгө, санхүүгийн нөөцийг тооцоогүй, шалгуур болон хүрэх түвшинг тодорхойлоогүй зорилт, арга хэмжээ төлөвлөсөн байна.

Хүснэгт 1.3

Бодлогын хамрах хүрээ	Ажлын явц, үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар үнэлэх	Хөрөнгө, санхүүгийн нөөцийг тооцоогүй	Шалгуур болон хүрэх түвшинг тодорхойлоогүй
I. Макро эдийн засгийн бодлого	2	11	-
II. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого	9	5	2
III. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	5	-	-
IV. Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого	4	6	-
V. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	12	5	2

1.8 Мөн бодлогын бичиг баримтад тулгуурласан, хариуцан хэрэгжүүлэгч зарим яамдын саналд үндэслээгүй зорилт арга хэмжээг төлөвлөсөн байна. Тухайлбал,

- Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалахын салбарын бодлогын хүрээний зорилт арга хэмжээ нь яамнаас хүргүүлсэн саналд тусгагдаагүй,
- Батлан хамгаалах салбарт ажиллах энгийн иргэн, боловсон хүчний бодлогыг шинэчлэх,
- Ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх,
- Цэргийн дайчилгааны бодлогод шинэчлэл хийж, дайчилгааны нөөц бүрэлдэхүүнийг сургах тогтолцоог боловсронгуй болгох

1.9 Үндсэн чиглэлд ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн “нэг цонхны бодлогоор” хэрэгжүүлэх гэсэн нэг агуулгатай 4.1, 9.2 дугаар арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн байна.

1.10 ТЕЗ-даас зорилтот түвшин, харгалзах үзүүлэлт, үр дагаврын хамрах хүрээг ерөнхий байдлаар төлөвлөдөг дутагдал давтагдсаар байгаа нь төлөвлөлтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүлээгдэж буй үр дүнг бодитой тооцох, байгууллагын ажлын зохион байгуулалт хангалтгүйтэй холбоотой байна.

1.11 Үндсэн чиглэлд зарим арга хэмжээг үйл ажиллагааны хэрэгжилт, явцыг 100 хувьд хүргэхээр төлөвлөж буй нь тухайн жилд биелэгдэх боломжгүй, оновчтой бус төлөвлөлт болсон байна. Тухайлбал,

- 5.1 Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг шинэчилж, салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх,
- 15.6 “Монгол залуу хүн” Үндэсний хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх,

20.6 “Архигүй Монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх

1.12 Зам, тээврийн салбарыг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор 1, 2 дугаар шатны төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, аймгуудын төвийг нийслэлтэй холбосон авто зам, хурдны зам барих ажил төлөвлөсөн ч зарим арга хэмжээний ТЭЗҮ, техникийн баримт бичгүүд ажлын даалгавар зэрэг бэлтгэл ажлууд хангагдаагүй ажлуудыг төлөвлөсөн байна.

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ бодитой бус төлөвлөгдсөн байна

1.13 Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд улсын төсөв, зээл, тусламж, концесс, сан, бусад эх үүсвэрээс нийт 1,164.9 тэрбум төгрөг төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 1.4
/тэрбум төгрөгөөр/

Эх үүсвэрийн ангилал	2014 он	2015 он
Улсын төсөв	362.5	645.9
Зээл	516.6	66.0
Тусламж	-	8.0
Концесс	-	100.0
Тусгай сан	-	25.0
Хувийн хэвшлийн хөрөнгө	4.0	-
Бусад эх үүсвэр	-	320.0
ДҮН	883.1	1,164.9

1.14 Үндсэн чиглэлийн нийт арга хэмжээний 29.7 хувь буюу 27 арга хэмжээ санхүүгийн эх үүсвэргүй батлагдсан бөгөөд улсын төсвөөс 54, зээл, тусламжийн эх үүсвэрээс 4, концесс болон бусад хувийн хэвшлийн хөрөнгөөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

1.15 Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 281.8 тэрбум төгрөгөөр, түүний дотор улсын төсвийн эх үүсвэр 283.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж төлөвлөгдсөн байна.

1.16 Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигт тусгасан боловч хариуцан ажиллах байгууллагын саналыг харгалзан үзэлгүй, тухайн ажлын анхан шатны бэлтгэл ажил, санхүүгийн баталгаатай байдал хангагдсан эсэх, хэрэгжих үндэслэл зэрэг нь тодорхойгүй ажлуудыг төлөвлөж байна.

Бүлэг 2. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 70 орчим хувийн биелэлттэй байна

2.1. Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 91 зорилт, арга хэмжээнээс хэрэгжсэн 45, хэрэгжилт дутуу 35, хэрэгжээгүй 11 арга хэмжээ буюу бодлогын таван үндсэн зорилтын дүнгээр 70.0 хувийн биелэлттэй байна.

2.2. Үндсэн чиглэлийн нийт арга хэмжээнээс зарим ТЕЗ-дын хариуцсан дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй арга хэмжээг шалтгаанаар нь судлан бүлэглэж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

▪ Төлөвлөлт, тооцоолол оновчгүй	16
▪ Санхүүжилт хүрэлцээгүй хөрөнгө батлагдаагүй	24
▪ Ажлын зохион байгуулалт дутагдалтай	2
▪ Хариуцан хэрэгжүүлэгч зохион байгуулалт өөрчлөгдсөн	4

2.3. 2015 оны дундаж хэрэгжилт 2014 оныхтой харьцуулбал хэрэгжээгүй арга хэмжээний тоо нэмэгдсэн боловч дундаж үнэлгээ 70.0 болж 7 пунктээр өссөн байна.

Хүснэгт 2.1

Үзүүлэлт	2012 он		2013 он		2014 он		2015 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хэрэгжсэн	17	29.4	55	11.7	32	30.7	45	49.4
Хэрэгжилт дутуу	120	63.2	101	82.8	62	60.3	35	38.4
Хэрэгжээгүй	8	7.4	10	5.5	10	9.0	11	12.2

2.4. Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бодлогын хамрах хүрээ, зорилт тус бүрээр нэгтгэн үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2.2

Бодлогын хамрах хүрээ	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээ /хувь/		
			СЯ	ЗГХЭГ	ҮАГ
I. Макро эдийн засгийн бодлого	4	10	83.0	78.0	76.0
II. ЭЗ-ийн өсөлтийг дэмжих салбарын бодлого	6	25	71.4	62.8	50.0
III. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого	4	13	80.0	67.6	67.7
IV. Хүний хөгжил, нийгмийг хөгжлүүлэх бодлого	5	21	87.1	85.3	82.9
V. Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого	5	22	82.3	86.3	78.6

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зарим зорилт хангагдаагүй байна

2.5. Макро эдийн засгийн бодлогын хүрээнд 4 зорилт, 10 арга хэмжээнээс хэрэгжсэн 4, хэрэгжилт дутуу 6 арга хэмжээ 76.0 хувийн биелэлттэй байна.

2.6. 2015 онд бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалах зорилт хангагдаагүй, улсын эдийн засгийн байдал өсөлтгүй гарсан байна.

Хүснэгт 2.3

Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Урьдчилсан* гүйцэтгэл	Зөрүү
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт (хувиар)	10.2	2.3	7.7
Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ (ам.доллараар)	5000 ам.доллараас дээш	4000	1000
Ажилгүйдлийн түвшин (хувиар)	6.6	8.3	1.7
Инфляцийн зорилтот түвшин (хувиар)	7.0	1.9	5.1
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого (тэрбум төгрөгөөр)	7,201.1	5,973.8	1,227.2
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын дээд хэмжээ (тэрбум төгрөгөөр)	7,690.9	7,137.0	553.9
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (тэрбум төгрөгөөр)	-489.8	-1,163.2	-673.4

*Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын тайлан

2.7. Макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж эдийн засгийг эрчимжүүлэх, тогтвортой байдлыг хангах чиглэлийн дараах арга хэмжээний хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна. Үүнд:

- 1.1 Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ 50 хувьтай, (СЯ)
- 3.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1,163.2 тэрбум төгрөгт хүрч төсвийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, төсвийн зохистой харьцааг хангах зорилт хангагдаагүй, (СЯ)
- 2.1 Ажилгүйдлийн түвшинг 6.6 хувьд хүргэх арга хэмжээ 8.3 хувь болж ажилгүйдлийн түвшин 1.7 пунктээр өссөн байна. (ХЯ)

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хэрэгжилт, үр дүн бага байгаагаас үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй байна

2.8. УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолын дагуу Засгийн газар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийг боловсруулан ажилласан байна.

2.9. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлын холбогдох газраас гаргасан тайлангаас үзэхэд татварын бодлогоор эдийн засгийг дэмжих чиглэлээр “Нэмэгдсэн өртгийн албан татвар”-ын хуулийн шинэчилсэн найруулга, “Татварын ерөнхий хууль” зэрэг эрх зүйн актыг батлуулж ажилласан байна.

2.10. Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбарт хөрөнгийн эх үүсвэр хангалттай төлөвлөгдөөгүй, Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хууль, төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусаагүй болон концессын гэрээ цуцлагдсантай холбоотойгоор эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх ач холбогдолтой дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- 8.1 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтэц байгуулах ажлыг эхлүүлэх, (ЗТЯ)
- 8.2 Мандал-Зуун мод-Бага хангай чиглэлд төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх, (ЗТЯ)
- 8.4 Алтанбулаг -Улаанбаатар –Замын-Үүдийн хурдны замын ажлыг эхлүүлэх, (АҮЯ)
- 8.5 Бичигт -Баруун урт чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах, (АҮЯ)
- 8.8 Нийтийн тээврийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх, (ЗТЯ)
- 10.2 Тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх төслийг хэрэгжүүлэх, (МТШХХГ)
- 10.3 Шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумыг өргөн зурвасын сүлжээнд холбох зэрэг арга хэмжээнүүд хэрэгжээгүй (МТШХХГ)

2.11. Түүнчлэн үндсэн чиглэлд жил бүр тусгагддаг ЗТЯ-ны хариуцан хэрэгжүүлсэн аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар холбох ажлыг үргэлжлүүлэх,

Замын-Үүдэд холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах арга хэмжээний хэрэгжилт 30 хувьтай буюу удаашралтай хэвээр байгаа нь бодлого, зохицуулалтын арга хэмжээг оновчтой хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

2.12. Эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын 6 зорилтын 25 арга хэмжээний хэрэгжилт 50 хувьтай биелж, 7 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилт 67.7 хувьтай байна

2.13. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд үндсэн чиглэлд 4 зорилт, 13 арга хэмжээ тусгагдснаас 2 арга хэмжээ нь хэрэгжээгүй, биелэлттэй 67.7 хувьтай байна.

2.14. Хөрөнгө батлагдаагүй, хариуцан хэрэгжүүлэх байгууллага өөрчлөгдсөн, тендер оройтсон зэрэг шалтгаан нөхцөлөөс болж дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүнд :

- 13.4 Ус, агаар, хөрсний чанарыг хянах шинжилгээний лабораторийн чадавхыг бэхжүүлж, орчны бохирдлын талаарх бодит мэдээллээр хангагдах, (БОНХАЖЯ)
- 14.2 Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг бий болгож, програм хангамж, техник хэрэгслийн хангалтыг сайжруулах(МХЕГ)

2.15. Түүнчлэн хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулах, эрчим хүчний хэмнэлттэй сэргээгдэх эрчим хүч болон хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах зэрэг хөдөөгийн хөгжлийг сайжруулах арга хэмжээнүүд 30-50 хувийн биелэлттэй байна.

Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын зорилт, арга хэмжээний биелэлт 82.9 хувьтай байна

2.16. Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх салбарын 5 зорилт, 21 арга хэмжээний биелэлт 82.9 хувьтай байгаагаас эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ахицтай ажиллаж зарим үр дүнтэй ажлууд хийгдсэн байна. Тухайлбал,

- ХАХНХЯ-наас 2014 онд төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулж нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ЗГХЭГ-т хүргүүлсэн ба УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 16-ны 53 дугаар тогтоолоор батлуулсан,
- Хүнсний эрхийн бичиг хөтөлбөрийн хүрээнд: 2015 оны улсын төсвөөс 18 тэрбум төгрөг батлагдсан ба ХАХНХ-ын сайдын А/20 тушаалаар хүнсний эрхийн бичгийн босго оноог 201,025 байсныг 240,317 болгож, хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлсэн ба сар бүр олгох эрхийн бичгийн мөнгөн дүнг 5,000 байсныг 6,500, том хүн 10,000 байсныг 13,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Улсын хэмжээнд хүн амын хамгийн бага хэрэглээтэй болох нийт 24642 өрхийн 135413 иргэнд хүнсний эрхийн бичгийн олголт хийгдсэн,
- Япон Улсын ЗГ-ын тусламжийн 300 сая иений буюу 5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 266 нэр төрлийн сэргээн засах тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна. Үүнээс: ХАХНХ сайдын А/133 тоот тушаалаар Сэргээн засалт хөгжлийн үндэсний төв, Ахмадын асрамж хөгжлийн үндэсний төв, Сүхбаатар дүүргийн Ахмадын асрамжийн төв, Хүүхэд гэр бүл хөгжлийн "Өнөр бүл" төв, Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Баянгол дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Нийслэлийн төв номын сан, 116 дугаар сургууль зэрэг газруудад тоног төхөөрөмжийг хуваарилсан байна.

2.17. Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын хүрээний зорилт арга хэмжээний дараах асуудлууд шийдлээ хүлээж байгаа бөгөөд биелэлтийн байдлыг авч үзвэл,

- 15.6 "Монгол Залуу хүн" Үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажил 50 хувьтай, ХАХНХЯ/
- 16.6 "Хотжилт ба эрүүл мэнд" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ 50 хувьтай, ЭМСЯ/

- 17.1 Биеийн тамир, спорт, соёл урлагийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болон ивээн тэтгэсэн хөрөнгийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил 50 хувьтай /ЭМСЯ/

2.18. Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын 21 зорилт, арга хэмжээнээс хэрэгжсэн 13, хэрэгжилт дутуу 7, үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэсэн 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын зарим зорилт арга хэмжээ төлөвлөлтөөс шалтгаалан дутуу хэрэгжсэн байна

2.19. Үндсэн чиглэлд засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх чиглэлээр 5 зорилт 22 арга хэмжээ батлагдаж ХЗЯ, ГХЯ, БХЯ хариуцан хэрэгжүүлсэн байна.

2.20. Энэ салбарт тавигдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 78.6 хувьтай үнэлэгдэж хэрэгжсэн 13, хэрэгжилт дутуу 8, батлан хамгаалах салбарт ажиллах энгийн иргэн, боловсон хүчний бодлогыг шинэчлэн боловсруулах гэсэн 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

2.21. Зарим арга хэмжээ хамтран хэрэгжүүлэгч байгууллагын ажлын уялдаагаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,

- Хууль зүйн салбарын хүрээнд “Архигүй Монгол хүн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,
- Эрх зүйн бакалаврын стандартад өөрчлөлт оруулж мөрдүүлэх,
- Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлэх ажлын явц урьдчилсан судалгаа хийж, төслийг боловсруулах

Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд төлөвлөгдсөн хөрөнгийн 80 орчим хувьд санхүүжилт олгогдоогүй байна

2.22. Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд нийт 226.9 тэрбум төгрөг зарцуулж 19.4 хувийг санхүүжүүлсэн нь гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж, хангалттай хэрэгжүүлэх бодитой эх үүсвэр болж чадаагүй байна. Санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 2.4

Төлөвлөгдсөн нийт дүн	Санхүүжилтийн зарцуулалт /тэрбум.төг/							
	Улсын төсөв	Концесс	Зээл	Тусламж	Тусгай сан	Бусад эх үүсвэр	Зарцуулсан дүн	Зөрүү
1,164.9	77.3	0	106.2	9.4	32.2	1.8	226.9	938.0

2.23. Санхүүжилтийн урьдчилсан гүйцэтгэлээс авч үзэхэд арга хэмжээнд улсын төсвөөс 77.3 тэрбум, зээл, тусламжаар 115.6 тэрбум, тусгай сангаас 32.2 тэрбум, бусад эх үүсвэрээс 1.8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.24. Эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан салбар бүрийн зорилт арга хэмжээний хэрэгжилт биелэлтийг хангах талаар зохиосон ажил бодитой үр дүнд хүрээгүй нь ТЕЗ-д зохион байгуулалтаар хангах болон бодлогын дэмжлэг үзүүлэх талаар хангалтгүй, улсын төсөвт шаардлагатай хөрөнгийг төсөвлөж, санхүүжүүлж чадаагүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Нөгөө талаас экспортын гол бүтээгдэхүүнүүдийн үнэ дэлхийн зах зээл дээр унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн орлогын хэмжээ буурч, санхүүжилт хангалтгүй хийгдсэн зэрэг нь үндсэн чиглэлийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

Бүлэг 3. ТЕЗ-д үндсэн чиглэлийн биелэлт, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна

3.1 Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 4 дүгээр бүлгийн 18 дахь заалтын дагуу ТЕЗ-д эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т тайлан ирүүлэхээр заасан.

3.2 Сангийн яамны үнэлгээгээр “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийн биелэлтийг 2015 оны жилийн эцсийн байдлаар 81.7 хувь гэж үнэлсэн ба нийт арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 35, 70-90 хувьтай 36, 30-50 хувьтай 14, хэрэгжээгүй 1, үнэлэгдээгүй 5 арга хэмжээ тус тус байна.

3.3 ҮАГ-аас зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин ТЕЗ болон ЗГХЭГ-ын тайлагналтай харьцуулан үнэлгээ хийлээ.

Хүснэгт 3

Д/д	ТЕЗ	Үнэлгээ /хувиар/		Аудитлагдсан /тоо/			
		Яам, агентлаг	ЗГХЭГ	ҮАГ	Хэрэгжсэн	Хэрэгжилт дутуу	Хэрэгжээгүй
1	БХБЯ	84.2	66.0	66.0	2	3	0
2	СЯ	80.0	80.0	70.0	1	4	0
3	БОНХАЖЯ	90.0	88.6	77.1	5	1	1
4	ХАХНХЯ	90.0	90.0	85.0	3	1	0
5	ЭМСЯ	97.1	87.1	84.2 *	5	2	0
6	УУЯ	84.0	70.0	62.0	2	3	0
7	АУЯ	75.5	77.1	60.0	5	2	2
8	ЭХЯ	88.6	70.0	70.0	2	1	0
9	БХЯ	87.5	90.0	60.0	1	2	1
10	ЗТЯ	76.0	57.5	24.0	0	2	4
11	ХХААЯ	82.3	83.3	73.0	1	2	0
12	БСШУЯ	88.7	87.1	83.3	2	4	0
13	ХЯ	90.0	86.7	83.3	1	2	0
14	ГХЯ	98.0	100	94.0	8	2	0
15	ХЗЯ	97.6	68.8	68.6	4	3	0
16	Монгол банк	100.0	100	100	2	0	0
17	МТШХХГ	50.0	50.0	10.0	0	0	2
18	ОБЕГ	100.0	100	100	1	0	0
19	ШЕЗ	0.0	70.0	70.0	0	1	0
20	МХЕГ	0.0	0.0	0.0	0	0	1

3.4 УИХ-ын 2014 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлт, Засгийн газрын 322 дугаар тогтоолын дагуу үндсэн чиглэлийн хэрэгжилт, биелэлтэд үнэлгээ хийхэд зарим арга хэмжээг үнэлээгүй, яамдын үнэлгээг зөрүүтэй тайлагнасан байна. Тухайлбал,

Үнэлгээ өгөгдөөгүй зорилт, арга хэмжээ:

- 8.1-ийн “1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх”,
- 8.8-ын “Нийтийн тээврийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх”,
- 8.4-ийн Алтанбулаг-Улаанбаатар-Замын- Үүдийн хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх,
- 8.5-ын “Бичигт-Баруун-Урт чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах”,
- 14.2-ын “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг бий болгож, программ хангамж, техник хэрэгслийн хангалтыг сайжруулах” зэрэг арга хэмжээнүүд байна.

Зарим яамдын хариуцан хэрэгжүүлсэн арга хэмжээний нийт үнэлгээг бууруулж тайлагнасан:

- Хууль зүйн яамнаас 97.6 хувиар үнэлсэн байхад 15.6 хувиар,
- ЭХЯ-наас 88.6 хувь гэсэн байхад 15.3 хувиар,
- Зам тээврийн яамнаас 76 хувь гэж үнэлсэн байхад 18 хувиар,
- БОНХАЖЯ-наас 90 хувь гэсэн байхад 1.4 хувиар

Арга хэмжээний нийт үнэлгээг нэмэгдүүлэн тайлагнасан:

- Барилга, хот байгуулалтын яамнаас 84.2 хувиар үнэлсэн байхад 2.2 хувиар,
- АҮЯ-наас 75.5 хувь гэсэн байхад 3.1 хувиар,
- БХЯ-наас 87.5 хувь гэсэн байхад 2.5 хувиар,
- ЭМСЯ-наас 95.7 хувь гэсэн байхад 1.4 хувиар,
- ХХААЯ-наас 82.3 хувь гэж үнэлсэн байхад 7.7 хувиар тус тус нэмэгдүүлэн зөрүүтэй тайлагнажээ.

3.5 Зарим яамдын ХШҮДАХ-ийн тайлан, яамны дотоод нэгжүүдээс зорилт арга хэмжээний биелэлтийг тайлагнасан байдал зэргийг нотлох баримттай тулган авч үзэхэд төсөл арга хэмжээний хэрэгжилтийг шалгууртай нь харьцуулан бодитой үнэлэлгүй, уг зорилт арга хэмжээнд өөр эх үүсвэрийн хүрээнд хийгдсэн арга хэмжээг хамааруулан бүрэн биелснээр дүнг өсгөж тайлагнасан байна. Тухайлбал,

- 10.1-ийн Эрдэм шинжилгээний туршилтын баазыг бэхжүүлж, төрөлжсөн эрдэм шинжилгээний лаборатори, туршилт-үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинээр байгуулах арга хэмжээ хөрөнгө төсвийн хүндрэлээс шалтгаалан барилгын ажлын гүйцэтгэлийг 100 хувь,
- 15.1-ийн Багш солилцооны хөтөлбөрт 40 багш хамруулахаас 22 багшийг хамруулж 100 хувь,
- 15.3-ын Инженерийн мэргэжлээр суралцагчдын сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн акт 100 хувь,
- 4.1-ийн Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээ 90 хувь,
- 8.2-ын Мандал – Зуунмод – Багахангай чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх ажил хэрэгжээгүй байхад 30 хувь,
- 9.4-ийн Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх 50 хувь,

3.6 Яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхид чанарын ахиц гарахгүй байгаа нь хэрэгжилтийг тайлагнасан байдлаас ажиглагдаж байгаа бөгөөд үр дүнд чиглүүлэн үнэлгээ хийдэггүй, үнэлгээ нь үр нөлөөтэй бодитой болж чадаагүй байна. Тухайлбал,

- ЭМСЯ үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүй Сангийн яаманд хүргүүлсэн,
- Монгол банк, МХЕГ үндсэн чиглэлийн тайланг 322 дугаар тогтоолд заасан хугацаанд нь хүргүүлээгүй.

Зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгоогүйгээс үнэлэхэд хүндрэлттэй байна

3.7 Бодлогын зарим зорилтын хүрээнд хамаарах дараах арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлоогүйгээс гүйцэтгэлийг үнэлэхэд хүндрэлттэй байна. Тухайлбал,

- 6.3 Ховд аймгийн Эрдэнэ бүрэн сумын УЦС-ыг барьж байгуулах бэлтгэлийг хангах, ТЭЗҮ болон зураг төслийг боловсруулах, төслийн нэгж ажиллуулах арга хэмжээ шалгуур үзүүлэлт хүрэх түвшинг тооцоогүй,
- 9.1 Дархан-Сэлэнгийн бүсэд металлургийн цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын ажлын хүрэх түвшин байхгүй,
- 20.5 Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх, тэднийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулах, зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх,
- 24.1 Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх,

- 23.1 Хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалж, "Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан"-гийн үйл ажиллагааг өргөжүүлэх

3.8 2015 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг ХЯ, УУЯ, ХХААЯ, АҮЯ, ЗТЯ, БХБЯ, ХЗЯ, ГХЯ, БХЯ хэлэлцүүлэг хийж, холбогдох дүгнэлт зөвлөмжийг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тодорхой чиглэл, шийдвэр гаргаагүй байна.

3.9 ТЕЗ-д суурь үзүүлэлтэд тулгуурлан үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэггүй, найдвартай хэмжүүрээр үр дүн, хүрэх түвшинг үнэлээгүй нь үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг Засгийн газрын 322 дугаар тогтоол болон үндсэн чиглэлийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүйтэй холбоотой байна.

3.10 ҮАГ-аас 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдалд аудит хийж Үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх бүх шатанд мэргэжил, арга зүйн нэгдсэн зөвлөгөө дэмжлэгээр хангаж ажиллах, мөн зорилт, арга хэмжээг Засгийн газраас баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих журам тогтоож мөрдүүлэх талаар зөвлөмж өгсөн боловч ТЕЗ-д өмнөх жилийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажил зохион байгуулсан талаар тайлан мэдээлэлд дурдаагүй байгаагаас үр дүнг тооцох боломжгүй байна.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр бодитой төлөвлөгдөөгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.
- Үндсэн чиглэлийн хэрэгжилт, биелэлтэд ТЕЗ-д нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаагүй нь арга хэмжээний хэрэгжилтэд нөлөөлсөн байна.
- Хүрэх үр дүн, хэрэгжилтийг үнэлэх шалгуур тодорхой бус арга хэмжээ үндсэн чиглэлд тусгагдсан нь тэдгээрийн гүйцэтгэлийг тооцох, үнэлж дүгнэхэд бэрхшээлтэй байна.
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг журмын дагуу үнэлж, тайлагнаж байх асуудалд ТЕЗ-даас тавих хяналт сул байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналд хяналт тавих журам боловсруулж мөрдүүлэх,
- Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг эх үүсвэр тус бүрээр нарийн тооцоолж тусгаж байх,
- Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг үр дүнтэй хийж, бодитой тайлагнах.



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2016 он 03 дугаар
сарын 29 ны өдөр

Дугаар АЗГ/553

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал өгөх тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналыг хүргүүлж байна.

Манай саналд дурдсан үндэслэлийг харгалзан үзэж Үндсэн чиглэлд заасан зарим арга хэмжээний гүйцэтгэлийг дахин хянан үзэх талаар арга хэмжээ авна уу.

Хавсралт 4 хуудас.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



С.БАЯРЦОГТ

Хавсралт

1. 6.2 Цахилгаан дамжуулах сүлжээний 220 квт, түүнээс дээш өндөр хүчдэлийн шугамыг байгуулах
Уг асуудлыг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж баталсан.
2. 8.1 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх
Ухаа худаг-Сайншанд баруун урт хөөт чиглэлийн төмөр замын техникийн зураг төслийг 100 хувь, тендерийн бичиг баримтыг 90 хувь, Хөөт төмөр чиглэлийн ТЭЗҮ төмөр замын ТӨХК-т батлагдсан. Эрдэнэт овоот чиглэлийн төмөр замын хөрөнгө оруулалтын газарт концессын гэрээ байгуулагдсан.
3. 8.2 Мандал –Зуун мод- Багахангай чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх
2015 оны 110 дугаар тогтоол гарсны дагуу техникийн туслалцааны 1.5 ам.доллараар Богдхан төмөр зам болон Улаанбаатар тээврийн логистик ТЭЗҮ, 2015.06.02нд азийн хөгжлийн банктай гарын үсэг зурсан.
4. 8.3 Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх
23 чиглэлд нийт 2753.9 км хатуу хучилттай авто замаар аймагийн төвүүдийг нийслэл хоттой холбох ажлыг хийсэн.
5. 8.4 Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүдийн хурдны зам авто замын барилгын ажлыг эхлүүлэх
2015 оны 3 дугаар сард зам тээврийн яамны дэргэдэх шинжлэх ухаан, технологийн зөвлөл хуралдаж Алтан булаг –Улаанбаатар- Замын Үүдийн хурдны авто замын чиглэлийн батлагдсан.
6. 8.5 Бичигт-Баруун Урт чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах
2015 оны 11 дүгээр сард БНХАУ-ын Бичигт Баруун урт чиглэлийн авто замыг барих асуудлаар санал тавьсан төслийн санхүүжилтийн хувьд баталгаа гаргах асуудлыг хөндсөн.
7. 9.4 Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх
Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 113 дугаар тогтоолыг батлуулсан.ТЭҮЗ боловсруулах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендерийг 2 үе шаттай зохион байгуулж, Евро-ойл ХХК-тай гэрээ байгуулсан.
8. 13.4 “Ус, агаар, хөрсний чанарыг хянах шинжилгээний лабораторийн чадавхийг бэхжүүлж, орчны бохирдлын талаарх бодит мэдээллээр хангагдах” арга хэмжээнд нээлттэй тендер зарласан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй, 1.5 тэрбум төгрөг татагдсан.

Үндэсний аудитын газрын тайлбар

Тайлбар 1

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар зээлийн гэрээ батлагдсантай холбоотойгоор хэрэгжилтийг 30 хувиар үнэлж өөрчлөв.

Тайлбар 2

2015 онд төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажил эхлээгүй байгаа тул 10 хувиар үнэлэгдсэн.

Тайлбар 3

Суурь бүтэц барьж байгуулах ажил эхлээгүй байгаа тул үнэлгээ өөрчлөх боломжгүй.

Тайлбар 4

2015 онд ашиглалтад оруулах 1400 км авто замаас Алтай-Дарви, Баян Хонгор-Алтай чиглэлийн замуудын ажил хөрөнгө санхүүгээс шалтгаалан удааширч, бусад чиглэлийн зам концесс эзэмшигч нар хөрөнгөө шийдэж чадаагүйгээс гэрээ цуцлагдсан тул үнэлгээг өөрчлөх боломжгүй.

Тайлбар 5

Засгийн газрын 2015 оны 158 дугаар тогтоодын дагуу концессын гэрээ цуцлагдсан үнэлгээ өөрчлөх боломжгүй.

Тайлбар 6

Концессын жагсаалтад оруулах саналыг хүргүүлсэн боловч хасагдсан учир хэрэгжээгүй.

Тайлбар 7

Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 113 дугаар тогтоол батлуулан зүүн бүсэд газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн концессын шийдвэр гарсан тул үнэлгээг 30 хувиар тооцов.

Тайлбар 8

Засгийн газрын 377 дугаар тогтоолын дагуу 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татагдсанаар ажил хийгдээгүй тул үнэлгээ өөрчлөх боломжгүй.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2016 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, Гүйцэтгэлийн шалгалтын журмын 23.2, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2016 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Сангийн сайд Б.Болор нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор /М.Наранжаргал/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

\\10.10.10.20\Bichig_Khereg\Tushaal\2016\0331GAG2.Docx

003279

Үндсэн чиглэлийн хэрэгжилт дутуу зорилт, арга хэмжээний жагсаалт

д/д		Бодлогын, зорилт арга хэмжээ	Аудитаар хүрсэн түвшин	Байгууллага
		Зорилт 1 Макро эдийн засгийн бодлогын хүрээний:		
1	1.1	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлэх	50	СЯ
2	2.1	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангуудыг нэгтгэх хууль эрх зүйн орчин бий болгох	70	Монголбанк
3	3.1	Төсвийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, төсвийн зохистой харьцааг хадгалах	50	СЯ
4	3.2	Орнуудтай байгуулсан давхар татварын гэрээг МУ-ын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгох	70	СЯ
5	3.3	Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох	80	СЯ
6	4.1	Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх	30	УУЯ
		Зорилт 2 Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээний:		
7	5.1	ХХАА -н талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчилж, салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлнэ.	50	ХХААЯ
8	5.2	Эрчимжсэн мал аж ахуй гахай шувууны аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэмжих зээлийн санг 50.0 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх	50	ХХААЯ
9	6.2	Цахилгаан дамжуулах сүлжээний 220 кВт, түүнээс дээш өндөр хүчдэлийн шугамыг байгуулах	30	ЭХЯ
10	8.3	Аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	30	АҮЯ
11	8.6	Замын-Үүд суманд холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах	30	ЗТЯ
12	8.7	Европын холбооны улсын нутаг дэвсгэрт агаарын тээвэрлэлтийн 5 дугаар эрх авах зохицуулалтыг бүрдүүлж, шинээр Сингапур, БНЭУ руу хуваарьт нислэг гүйцэтгэх	50	ЗТЯ
13	9.2	Экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх	30	УУЯ
14	9.4	Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барьж эхлэх	30	АҮЯ
15	9.5	Нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтын үйлдвэрийг ажиллуулж эхлэх	30	УУЯ
16	10.1	Эрдэм шинжилгээний туршилтын баазыг бэхжүүлж, төрөлжсөн эрдэм шинжилгээний лаборатори, туршилт-үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинээр байгуулах	70	БСШУЯ
		Зорилт 3 Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээний:		
17	11.1	"МУ-ын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл"-ийг боловсруулах	50	БХБЯ
18	11.3	Газрын бирж байгуулах ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлэх	70	БХБЯ
19	12.3	Улс, бүс нутгийн онцгой ач холбогдол бүхий боомтуудын дэд бүтэц, байгууламжийг цогцоор нь байгуулах	30	БХБЯ
20	13.5	Эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч болон хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах "Ногоон барилга" санаачилгыг нэвтрүүлэх	30	БОНХАЖЯ
		Зорилт 4 Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын хүрээний:		
21	15.1	Боловсролын байгууллагын олон улсын багш солилцооны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	80	БСШУЯ
22	15.3	Багш инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	80	БСШУЯ
23	15.5	Их дээд сургуулиудыг түшиглэн "Цахим сургалтын үндэсний төв" байгуулах	70	БСШУЯ
24	15.6	"Монгол залуу хүн" Үндэсний хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх	40	ХАХНХЯ
25	16.6	Хүн амын эрүүл мэндэд хотжилтын нөлөөлөх нөлөөг судлан "Хотжилт ба эрүүл мэнд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	50	ЭМСЯ
26	17.1	Биеийн тамир, спорт, соёл, урлагийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт болон ивээн тэтгэсэн хөрөнгийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	50	ЭМСЯ
27	19.5	Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний шатлал болон тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх	80	ХЯ

Зорилт 5 Засаглал, ЭЗ шинэчлэл, ГБ, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээний:				
28	20.2	ШЗ, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон стандарт, журмыг батлан мөрдүүлэх	70	ХЗЯ
29	20.3	Эрх зүйн бакалаврын стандартад өөрчлөлт оруулж, мөрдүүлэх	50	ХЗЯ
30	20.4	Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлэх	30	ХЗЯ
31	20.6	"Архигүй Монгол хүн" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	30	ХЗЯ
32	21.2	Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах	50	ГХЯ
33	21.3	ЗХА-ийн асуудлаарх УБ-ын яриа хэлэлцээ санаачилгыг бусад улсад таниулах, дэмжлэг авах чиглэлээр ажиллах	80	ГХЯ
34	24.3	Цэргийн дайчилгааны бодлогод шинэчлэл хийж, дайчилгааны нөөц бүрэлдэхүүнийг сургах тогтолцоог боловсронгуй болгох	80	БХЯ
35	24.6	Ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх болон экологийн төрөл бүрийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд цэргийн хүчний оролцоог нэмэгдүүлэх	60	БХЯ

Үндсэн чиглэлийн хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний жагсаалт

д/д		Бодлогын, зорилт арга хэмжээ	Хэрэгжээгүй шалтгаан	Хэрэгжүүлэгч байгууллага
		Зорилт 2 Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээний:		
1	8.1	1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтэц барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Санхүүжилт хүрэлцээгүйгээс	ЗТЯ
2	10.2	Өндөр нарийвчлал бүхий тандан судалгааны хиймэл дагуул хөөргөх төслийг хэрэгжүүлэх		МТШХХГ
3	10.3	Шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг өргөн зурвасын сүлжээнд холбох		
4	8.2	Мандал, Зуун мод, Багахангай чиглэлд Улаанбаатар хотыг тойруулан төмөр замын суурь бүтэц барьж байгуулах	Төлөвлөлт тооцоолол оновчгүйгээс	ЗТЯ
5	8.4	Алтанбулаг-Улаанбаатар-Замын-үүдийн хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх		АҮЯ
6	8.5	Бичигт-Баруун-Урт чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах		ЗТЯ
7	8.8	Нийтийн тээврийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх		ЗТЯ
		Зорилт 3 Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээний:		
8	13.4	Ус, агаар, хөрсний чанарыг хянах шинжилгээний лабораторийн чадавхыг бэхжүүлж, орчны бохирдлын талаарх бодит мэдээллээр хангагдах	Санхүүжилт хүрэлцээгүйгээс	БОНХАЖЯ
9	14.2	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх удирдлага, мэдээллийн системийг бий болгож, программ хангамж, техник хэрэгслийн хангалтыг сайжруулах		МХЕГ
		Зорилт 4 Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлогын хүрээний:		
10	19.3	Үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Төлөвлөлт тооцоолол оновчгүйгээс	АҮЯ
		Зорилт 5 Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээний:		
11	24.5	Батлан хамгаалах салбарт ажиллах энгийн иргэн, боловсон хүчний бодлогыг шинэчлэн боловсруулах		БХЯ